



ТӨВ АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/465

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/50 дугаар тушаал, Батлан хамгаалахын сайд аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний 1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулах Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнд оролцох тасгийн жигдрэлт, аюулгүй ажиллагааг ханган амжилттай оролцуулахыг Цэргийн штабын дарга дэд хурандаа (Т.Төмөрчөдөр)-д үүрэг болгосугай.

2. Тэмцээнд оролцох сурагчдыг жагсаалын бэлтгэл жигдрэлтийг хангахад шаардагдах материал хэрэгслээр дэмжлэг үзүүлж мэргэжлийн дасгалжуулагч багшийг томилж дэмжлэг үзүүлж ажиллахыг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч, хурандаа (Ж.Мөнхбаяр)-д даалгасугай.

3. Тэмцээнд оролцох сурагчдад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол шинжлэх ухааны газрын дарга (Ц.Нарантуяа)-д даалгасугай.

4. Тэмцээн оролцох баг, тамирчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах, тэмцээний бэлтгэлийн үед анхан шатны тусламж үзүүлэх зааварлагч эмчийг томилон ажиллуулахыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга (Н.Энхтайван)-д даалгасугай.

5. Улсын аварга шалгаруулах Цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээний удирдамжийн дагуу 2022 оны 08 дугаар сарын 15-наас 20-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн сургалтын төвийг түшиглэн бэлтгэлийг хангахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн захирагч, хурандаа (Ц.Буянжаргал)-д үүрэг болгосугай.


6. Тэмцээнд оролцох бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёр, гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

7. Тэмцээнд оролцох бие бүрэлдэхүүний ирж, очих тээвэрлэх авто техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, тээвэрлэх үеийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цэргийн штабын дарга дэд хурандаа (Т.Төмөрчөдөр)-д үүрэг болгосугай.

8. Тэмцээнд шаардагдах зардал 6,996,416 (зургаан сая есөн зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун дөчин зургаа) төгрөгийг аймгийн төсвийн хуваарилагдаагүй зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю. Бямбацогт)-д, шилэн дансанд байршуулахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР



Сонхиргоо